

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelqerb@audit.gov.mn](mailto:tegshdelqerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Гурван Хөх Морьт Аудит ХХК  
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг  
Утас:99051815 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Аудитор: Ш.Саранчимэг  
Утас:99834361 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АХМАД НАСТНЫ  
АСРАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
Ч.ЭНХБАТ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/253  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн барилгад 2024 онд гал гарч барилгын баруун жигүүрийн хэсэг галд автсан ба тус барилга нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн "Хөрөнгө актлах тухай" А/58 дугаар захирамжаар акталж, данснаас хассан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагнал, хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалттай холбоотой 53,895.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 50,932.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 төлбөрийн акт, зөвлөмж хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Дээд шатны төсвийн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хангалттай хэрэгжүүлэн ажилласан байна.

671201782

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,359,011.45</b>	<b>102,685,944.00</b>
33	<b>АВЛАГА</b>	14,966,517.00	8,745,858.00
335	<b>Бусад авлага</b>	14,966,517.00	8,745,858.00
<b>3352</b>	Хувь хүмүүсээс авах авлага	14,966,517.00	8,745,858.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	63,392,494.45	93,940,086.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11,025,672.00	11,222,548.00
35110	Эм боох материал	11,025,672.00	11,222,548.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,366,822.45	82,717,538.00
35410	Бичиг хэргийн материал	205,200.00	-
35420	Аж ахуйн материал	45,446,580.00	41,049,430.00
35450	Барилгын засварын материал	-	38,086,000.00
35460	Хүнсний материал	2,346,542.45	3,582,108.00
35470	Бусад хангамжийн материал	4,368,500.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,406,016.27</b>	<b>87,953,249.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	102,406,016.27	87,953,249.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	31,736,882.99	17,468,683.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,048,781.00	3,047,911.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(63,182,098.40)	(1,417,474.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,300,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,650,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,445,900.00	32,975,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,796,233.59)	(19,442,233.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,343,320.00	6,343,320.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,772,786.02)	(4,038,739.94)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>70,669,133.28</b>	<b>70,484,566.56</b>
39301	Программ хангамж	553,700.00	553,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(184,566.72)	(369,133.44)
<b>39303</b>	<b>Бусад биет бус хөрөнгө</b>	70,300,000.00	70,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>180,765,027.72</b>	<b>190,639,193.99</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>180,765,027.72</b>	<b>190,639,193.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	180,765,027.72	190,639,193.99
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	194,236,436.00	194,236,436.00
<b>51101</b>	<b>Өмч: - төрийн</b>	194,236,436.00	194,236,436.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(26,168,472.40)</b>	<b>(16,294,306.13)</b>
<b>51210</b>	<b>Өмнөх үеийн үр дүн</b>	(26,168,472.40)	(26,168,472.40)
<b>51220</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	-	9,874,166.27
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	12,697,064.12	12,697,064.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>180,765,027.72</b>	<b>190,639,193.99</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>752,928,770.00</b>	<b>905,008,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>20,070,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	20,070,000.00

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>120004</b>	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	20,070,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		20,070,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>752,928,770.00</b>	<b>884,938,700.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>694,946,900.00</b>	<b>804,100,400.00</b>
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	694,946,900.00	804,100,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,981,870.00</b>	<b>80,838,300.00</b>
131101	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөн		8,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан т		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	57,981,870.00	72,338,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>767,192,609.54</b>	<b>891,739,200.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>767,192,609.54</b>	<b>891,739,200.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	672,937,791.74	883,714,171.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>330,497,287.17</b>	<b>490,428,438.36</b>
210101	Үндсэн цалин	233,022,724.23	342,008,129.69
210102	Нэмэгдэл	69,205,523.34	142,765,662.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	28,269,039.60	5,654,646.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,879,938.34</b>	<b>62,258,993.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,357,603.81	41,647,498.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,818,520.63	5,958,420.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,352.41	2,470,177.79
210204	Ажилгүйдлийн даатгал	631,860.14	2,430,459.42
210205	Эрүүл мэндийн даатгал	6,438,601.35	9,752,437.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,088,893.65</b>	<b>37,536,697.86</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,318,385.83	9,804,283.38
210302	Түлш, халаалт	23,247,820.32	23,302,439.48
210303	Цэвэр, бохир ус	9,522,687.50	4,429,975.00
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,406,236.00</b>	<b>35,233,530.00</b>
210401	Бичиг хэрэг	1,494,450.00	1,570,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,499,710.00	2,042,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,090.00	198,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329,000.00	341,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,646,986.00	24,772,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,309,130.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>170,112,407.15</b>	<b>209,287,188.45</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,997,701.60	3,021,044.00
210502	Хоол, хүнс	127,975,705.55	158,165,544.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,139,000.00	48,100,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,836,900.00</b>	<b>25,627,390.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		
<b>210604</b>	<b>Урсгал засвар</b>	<b>26,836,900.00</b>	<b>25,627,390.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>415,700.00</b>	<b>-</b>
<b>210702</b>	<b>Дотоод албан томилолт</b>	<b>415,700.00</b>	<b>-</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,497,600.00</b>	<b>12,284,500.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>7,705,000.00</b>	<b>10,550,500.00</b>
<b>210802</b>	<b>Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох</b>	<b>-</b>	<b>1,080,000.00</b>
<b>210803</b>	<b>Даатгалын үйлчилгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>210804</b>	<b>Тээврийн хэрэгслийн татвар</b>	<b>96,800.00</b>	<b>-</b>

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	56,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	639,400.00	654,000.00
210807	Газрын төлбөр		
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,202,829.43</b>	<b>11,057,433.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,202,829.43	11,057,433.06
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>94,254,817.80</b>	<b>8,025,029.29</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,400,000.00</b>	<b>6,820,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,445,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,955,000.00	6,820,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,854,817.80</b>	<b>1,205,029.29</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,854,817.80	1,205,029.29
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(14,263,839.54)</b>	<b>13,269,499.49</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,701,600.00</b>	<b>3,395,333.22</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,395,333.22
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,701,600.00)</b>	<b>(3,395,333.22)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(15,965,439.54)</b>	<b>9,874,166.27</b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(10,203,032.86)	196,730,467.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(10,203,032.86)	196,730,467.26
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,965,439.54)	(15,965,439.54)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(26,168,472.40)	180,765,027.72
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(26,168,472.40)	180,765,027.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(26,168,472.40)	180,765,027.72
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	9,874,166.27	9,874,166.27
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,236,436.00	12,697,064.12	(16,294,306.13)	190,639,193.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>752,928,770.00</b>	<b>891,159,359.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>6,220,659.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	6,220,659.00
120009	Бусад орлого	-	6,220,659.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>752,928,770.00</b>	<b>884,938,700.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>694,946,900.00</b>	<b>804,100,400.00</b>

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	694,946,900.00	804,100,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,981,870.00</b>	<b>80,838,300.00</b>
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,500,000.00
131103	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,981,870.00	72,338,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>749,228,770.00</b>	<b>891,159,359.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>749,228,770.00</b>	<b>891,159,359.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>654,973,952.20</b>	<b>883,134,329.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>330,497,287.17</b>	<b>490,428,438.36</b>
210101	Үндсэн цалин	237,627,799.23	342,008,129.69
210102	Нэмэгдэл	69,205,523.34	142,765,662.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	23,663,964.60	5,654,646.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,560,301.05</b>	<b>62,258,993.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,998,315.06	41,647,498.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,858,172.09	5,958,420.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,352.41	2,470,177.79
210204	Ажилгүйдлийн даатгал	631,860.14	2,430,459.42
210205	Эрүүл мэндийн даатгал	6,438,601.35	9,752,437.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,501,633.98</b>	<b>37,536,697.86</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,318,385.83	9,804,283.38
210302	Түлш, халаалт	23,247,820.32	23,302,439.48
210303	Цэвэр, бохир ус	9,935,427.83	4,429,975.00
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,568,436.00</b>	<b>30,433,200.00</b>
210401	Бичиг хэрэг	1,428,650.00	1,365,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,499,710.00	1,917,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,090.00	198,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329,000.00	341,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,874,986.00	26,611,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>173,025,094.00</b>	<b>205,979,110.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,053,749.60	2,720,900.00
<b>210502</b>	<b>Хоол, хүнс</b>	<b>131,157,344.40</b>	<b>159,526,110.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,814,000.00	43,732,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,636,900.00</b>	<b>44,213,390.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,800,000.00	-
210604	Урсгал засвар	26,836,900.00	44,213,390.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>415,700.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томиллолт	415,700.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,768,600.00</b>	<b>12,284,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,705,000.00	10,550,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,800.00	-

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	56,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	910,400.00	654,000.00
210807	Газрын төлбөр		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
<b>210902</b>	<b>Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх</b>		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>94,254,817.80</b>	<b>8,025,029.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,400,000.00</b>	<b>6,820,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,445,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,955,000.00	6,820,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,854,817.80</b>	<b>1,205,029.29</b>
<b>213303</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>48,854,817.80</b>	<b>1,205,029.29</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,700,000.00</u></b>	
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,700,000.00</b>	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,700,000.00</b>	
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,700,000.00</b>	
<b>225106</b>	<b>Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал</b>	<b>3,700,000.00</b>	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(3,700,000.00)</u></b>	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>804,100,400.00</b>	<b>802,895,370.71</b>	<b>1,205,029.29</b>	<b>99.9%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>804,100,400.00</b>	<b>802,895,370.71</b>	<b>1,205,029.29</b>	<b>99.9%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>804,100,400.00</b>	<b>802,895,370.71</b>	<b>1,205,029.29</b>	<b>99.9%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>484,897,500.00</b>	<b>484,207,779.36</b>	<b>689,720.64</b>	<b>99.9%</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	293,842,100.00	335,787,470.69	(41,945,370.69)	114.3%
<b>210102</b>	Нэмэгдэл	189,428,800.00	142,765,662.42	46,663,137.58	75.4%
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	#DIV/0!
<b>210104</b>	Урамшуулал	1,626,600.00	5,654,646.25	(4,028,046.25)	347.6%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,467,000.00</b>	<b>62,258,993.49</b>	<b>208,006.51</b>	<b>99.7%</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	42,174,600.00	41,647,498.29	527,101.71	98.8%
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	5,407,200.00	5,958,420.42	(551,220.42)	110.2%
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	3,969,400.00	2,470,177.79	1,499,222.21	62.2%
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	992,400.00	2,430,459.42	(1,438,059.42)	244.9%
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	9,923,400.00	9,752,437.57	170,962.43	98.3%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,841,700.00</b>	<b>37,536,697.86</b>	<b>305,002.14</b>	<b>99.2%</b>
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	10,052,300.00	9,804,283.38	248,016.62	97.5%
<b>210302</b>	Түлш, халаалт	23,302,500.00	23,302,439.48	60.52	100.0%
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	4,486,900.00	4,429,975.00	56,925.00	98.7%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>210401</b>	Бичиг хэрэг	<b>14,365,100.00</b>	<b>14,364,000.00</b>	<b>1,100.00</b>	<b>100.0%</b>
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	1,365,100.00	1,365,100.00	-	100.0%
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,503,100.00	1,502,000.00	1,100.00	99.9%

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,900.00	198,900.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	341,000.00	341,000.00	-	100.0%
2105	<b>Нормативт зардал</b>	10,957,000.00	10,957,000.00	-	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	<b>190,639,800.00</b>	<b>190,638,610.00</b>	<b>1,190.00</b>	<b>100.0%</b>
210502	Хоол, хүнс	1,155,400.00	1,155,400.00	-	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159,527,300.00	159,526,110.00	1,190.00	100.0%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,957,100.00	29,957,100.00	-	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210602	Тавилга				
210604	Урсгал засвар	12,155,300.00	12,155,290.00	10.00	100.0%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>				
210702	Дотоод албан томилолт				
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,734,000.00</b>	<b>1,734,000.00</b>	-	<b>100.0%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	#DIV/0!
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	654,000.00	654,000.00	-	100.0%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>				
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>				
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>804,100,400.00</b>	<b>802,895,370.71</b>	<b>1,205,029.29</b>	<b>99.9%</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>804,100,400.00</b>	<b>802,895,370.71</b>	1,205,029.29	99.9%
320001	Орон нутгийн төсвөөс	804,100,400.00	802,895,370.71	1,205,029.29	99.9%
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>				
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1</b>	<b>1</b>	-	<b>100.0%</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	-	<b>100.0%</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24</b>	<b>24</b>		
620001	Удирдах ажилтан	1	1		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8	1	88.9%
620003	Үйлчлэх ажилтан	15	15		100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>80,838,300.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>80,838,300.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>74,018,300.00</b>

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,069,200.00</b>
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	415,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,654,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>15,340,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,565,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,775,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,058,100.00</b>
210106	Багаж, техник, хэрэгсэл	
210602	Тавилга	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	
210604	Урсгал засвар	32,058,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	
210702	Дотоод албан томилолт	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,550,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,550,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,820,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,820,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,820,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>80,838,300.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,838,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,338,300.00

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт бараа материал, цалин, үндсэн хөрөнгийн тайлагналтай холбоотой нийт 53,895.8 мянган төгрөгийн 8 алдаа илэрсэнээс аудитын явцад 50,932.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2,963.2 мянган төгрөгийн 5 алдааг дахин давтан гаргахгүй байх 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж хүргүүлэв.

Залруулсан алдаа:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээнээс 8,500.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулахад 2 байгууллагын 36,211.9 мянган төгрөгийн мэдээлэл, 1 байгууллагын 27,175.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус дутуу байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг дагаж мөрдөөгүй байна.
- Тайлант хугацаанд төлөгдсөн авлага 6,220.6 мянган төгрөгөөр Мөнгөн гүйлгээний тайлангийн орон нутгийн санхүүжилтийг нэмэгдүүлэн тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон

улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- **3.1 Төлбөрийн акт**

Илрүүлэлт: Бичиг хэрэг, архивын ажилтанд архивын ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл 20 хувийг 4 сарын хугацаанд 962.0 мянган төгрөг олгосон, ахлах нягтлан бодогч 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг 80 хувь буюу 1,247.2 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заалтыг мөрдөөгүй бөгөөд "Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна."

Өгсөн албан шаардлага: Илүү тооцон олгосон нэмэгдэл цалин хөлсийг төсөвт буцаан төвлөрүүлэх

- **3.2 Албан шаардлага**

- Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

- **3.3 Зөвлөмж**

- Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 5 нэр төрлийн 6 ширхэг 3,439.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 5 нэр төрлийн 6 ширхэг 3,439.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансны үнийг шинэчлэн тогтоож, үр дүнг бүртгэл тайланд тусгах

2.Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинжтэй 49 нэр төрлийн 204 ширхэг 57,669.9 мянган төгрөгийн хөрөнгө бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", СС-ын 229-р тушаалаар батлагдсан журмын 10.6.Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.",

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангиллыг мөрдөж ажиллах

### **3. Эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хоолны зардлаас 125.0 мянган төгрөгөөр тээвэр шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 629.0 мянган төгрөгөөр угаалгын машин худалдан авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллаагүй мөн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бүртгэлийг үнэн зөв бодитой бүртгэх

#### 4. Ахмадын сантай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Ахмадын сан: Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь ахмадын сан байгуулаагүй байна. Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7-р заалт, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг зөрсөн ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ахмадын сан байгуулж, журмын дагуу ажиллуулах

#### 5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Ахмадын асрамж үйлчилгээний төвийн даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “НБББББ”-т “сандал, ширээ, шүүгээ, бүх төрлийн цахилгаан барааг үнэ харгалзахгүйгээр бараа материалд бүртгэхээр тусгасан, мөн 2019 оноос хойш шинэчлэн батлаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангиллыг стандартад нийцүүлэн “НБББББ”-т тусган мөрдөх, шинэчлэн батлах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан байна.	1	44,711.9	1	44,711.9	1	44,711.9		
Тайлант хугацаанд төлөгдсөн авлага 6,220.6 мянган төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайлангийн орон нутгийн санхүүжилтийг нэмэгдүүлэн тайлагнасан байна	1	6,220.6	1	6,220.6	1	6,220.6		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>50,932.5</b>	<b>2</b>	<b>50,932.5</b>	<b>2</b>	<b>50,932.5</b>		

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшууллыг илүү тооцож олгосон.	1	2,209.2	1	2,209.2				
Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг шийдээгүй	1	-					1	-
Хөрөнгө, материал зөв ангилж бүртгээгүй	1	-					1	-
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	754.0					1	754.0
НБББББ-ийг шинэчлээгүй	1	-					1	-
Дүн	5	2,963.2	1	2,209.2			4	754.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын сан байгуулаагүй	1					-	1	-
Дүн	1	-					1	-